210301	3.1.01.2.1.1.3.01 Гэрэл, цахилгаан	64,319,900.00	36,349,160.82
210302	3.1.01.2.1.1.3.02 Түлш, халаалт	331,170,800.00	359,409,671.15
210303	3.1.01.2.1.1.3.03 Цэвэр, бохир ус	7,002,800.00	1,080,000.00
2104	3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	34,398,100.00	29,645,968.00
210401	3.1.01.2.1.1.4.01 Бичиг хэрэг	4,055,000.00	2,989,400.00
210402	3.1.01.2.1.1.4.02 Тээвэр, шатахуун	20,274,700.00	18,746,843.00
210403	3.1.01.2.1.1.4.03 Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,886,100.00	1,352,700.00
210405	3.1.01.2.1.1.4.05 Хог хаягдал зайлуулах, хортон мэргэгчдийн устгал, ариутгал	5,400,000.00	5,145,225.00

210406	3.1.01.2.1.1.4.06 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,782,300.00	1,411,800.00
2106	3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	53,765,700.00	53,507,837.11
210601	3.1.01.2.1.1.6.01 Багаж, техник, хэрэгсэл	8,500,000.00	8,500,000.00
210603	3.1.01.2.1.1.6.03 Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	998,200.00	743,600.00
210604	3.1.01.2.1.1.6.04 Урсгал засвар	44,267,500.00	44,264,237.11
2107	3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал	6,151,300.00	6,070,000.00
210702	3.1.01.2.1.1.7.02 Дотоод албан томилолт	6,151,300.00	6,070,000.00
2108	3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,963,400.00	6,224,091.00
210801	3.1.01.2.1.1.8.01 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	619,200.00	226,420.00
210802	3.1.01.2.1.1.8.02 Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	619,200.00	-
210803	3.1.01.2.1.1.8.03 Даатгалын үйлчилгээ	300,000.00	-
210804	3.1.01.2.1.1.8.04 Тээврийн хэрэгслийн татвар	255,000.00	251,308.00
210805	3.1.01.2.1.1.8.05 Тээврийн хэрэгслийн оношилгоо	165,000.00	99,000.00
210806	3.1.01.2.1.1.8.06 Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,279,000.00	5,150,000.00
210807	3.1.01.2.1.1.8.07 Газрын төлбөр	726,000.00	497,363.00
2109	3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	51,231,600.00	38,493,930.00
210901	3.1.01.2.1.1.9.01 Бараа үйлчилгээний бусад зардал	46,738,000.00	36,181,130.00
210902	3.1.01.2.1.1.9.02 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,493,600.00	2,312,800.00
213	3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,250,000.00	1,857,200.00
2132	3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	3,250,000.00	1,857,200.00
213209	3.1.01.2.1.4.2.08 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,250,000.00	1,857,200.00
22	3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	305,000,000.00	216,072,100.00
223001	3.1.01.2.2.4 Бусад хөрөнгө	305,000,000.00	216,072,100.00
23	3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	201,470,500.00	-
230001	3.1.01.2.3.1 Эргэж төлөгдөх зээл	201,470,500.00	-
8	3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	1,140,151,400.00	(108,733,698.63)
9	3.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(1,140,151,400.00)	108,733,698.63
7	3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(1,140,151,400.00)	108,733,698.63
4	4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	302,133,771.44
5	5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	193,400,072.81
6	6 ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	60.00	56.00
61	6.1 БАЙГУУЛЛАГЫН ТОО	2.00	2.00
610001	6.1.01 Төсвийн байгууллага	2.00	2.00
62	6.2 АЖИЛЛАГСДЫН ТОО	29.00	27.00
620001	6.2.01 Удирдах ажилтан	8.00	8.00
620002	6.2.02 Гүйцэтгэх ажилтан	11.00	10.00
620003	6.2.03 Үйлчлэх ажилтан	3.00	3.00
620004	6.2.04 Гэрээт ажилтан	7.00	6.00
65	6.5 ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	29.00	27.00
650001	6.5.01 Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	11.00	11.00
650009	6.5.09 Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	6.00	5.00
650010	6.5.10 Гэрээт ажилтан	5.00	4.00
650011	6.5.11 Улс төрийн албан хаагч (УТ)	7.00	7.00

2.6. Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Тайлант он
1	1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	4,371,372.00
12	1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,371,372.00
122	1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	4,371,372.00
1221	1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	4,371,372.00
12213	1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	4,371,372.00
350011	1.1.1.1.1.1.1.1.1 Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	100,000.00
350014	1.1.1.1.1.1.1.1.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00
350015	1.1.1.1.1.1.1.1.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,271,372.00
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,371,372.00
21	1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	4,371,372.00
210	1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,531,372.00
2101	1.1.1.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	514,500.00
210101	1.1.1.2.1.1.1.1 Үндсэн цалин	514,500.00
2102	1.1.1.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,167.00
210201	1.1.1.2.1.1.2.1 Тэтгэврийн даатгал	59,167.00
2104	1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	1,957,705.00
210402	1.1.1.2.1.1.4.2 Тээвэр, шатахуун	1,957,705.00
213	1.1.1.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,840,000.00
2132	1.1.1.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	1,840,000.00
213209	1.1.1.2.1.4.2.8 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,840,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Зүүнхангай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь байгууллагын манлайллыг дээшлүүлэх, хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг түргэн шуурхай зохион байгуулах, төрийн албан хаагчдын ёс зүйг чанд сахиж иргэдэд төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай хүргэх гэсэн зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль,
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль,
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль
- Малын тоо толгойн албан татварын тухай
- Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”
- Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”;

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр, 07 дугаар сарын 09-ны өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.
- Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.
- Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд - Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.1, 13.1.2 дахь заалтуудыг 2025.01.01-ээс мөрдөнө.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зүүнхангай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Зүүнхангай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 179.2 сая төгрөгөөр буюу 5.2 хувиар өссөн байна.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/Сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	302.1	193.4	-108.7
Авлага	199.6	166	-33.6
Бараа материал	174.7	145.2	-29.5
Үндсэн хөрөнгө	2,787.0	3,138.0	351.0
Нийт хөрөнгө	3,463.4	3,642.6	179.2
Өр төлбөр	1.8	80.4	78.6
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,461.6	3,562.2	100.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,463.4	3,642.6	179.2

Эх сурвалж: Зүүнхангай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 193.4 сая төгрөг болж өмнөх оноос 108.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/Сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Б	1	2	3=2-1
Төрийн сангийн харилцах	302.1	193.4	-108.7
Дүн	302.1	193.4	-108.7

Эх сурвалж: Зүүнхангай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 193.4 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд байршиж байна. Үүнд: Орон нутгийн ерөнхий орлого 76.8 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн 37.1 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн 79.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 191.4 сая төгрөгөөс эцсийн үлдэгдэл 161.3 сая төгрөг болж 30.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл

/Сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Б	1	2	3=2-1
Байгууллагаас авах авлага	0.2	1.4	1.2
Хувь хүмүүсээс авах авлага	37.8	37.8	0
Зээлийн авлага	153.4	122.1	-31.3
Дүн	191.4	161.3	-30.1

Эх сурвалж: Зүүнхангай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэл буурахад Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлага 31.3 сая, зээлийн хүүгийн авлага 3.6 сая, Засаг даргын тамгын газрын байгууллагаас авах авах авлага 0.2 сая төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлжээ.

3.5.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 174.7 сая төгрөг байснаас эцсийн үлдэгдэл 145.2 сая төгрөг болж 29.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл

/Сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Б	1	2	3=2-1
Бичиг хэргийн материал	15.4	14.3	-1.1
Аж ахуйн материал	51.6	51.6	0
Бусад хангамжийн материал	95.9	53.7	-42.2
Мал амьтад	11.8	25.6	13.8
Дүн	174.7	145.2	-29.5

Эх сурвалж: Зүүнхангай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засаг даргын тамгын газрын бичиг хэргийн материал, бусад хангамжийн материалын үлдэгдэл 29.5 сая төгрөгөөр буурсан нь бараа материалын үлдэгдэл буурахад нөлөөлжээ.

Бараа материалын данстай холбоотой Төсвийн шууд захирагчдын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 7.7 сая төгрөгийн 1 алдаа илэрсэн. Үүнд:

Аудитын илрүүлэлт:

Зүүнхангай сумын Засаг даргын тамгын газар:

1. Тамгын газрын бараа материалын тайлангийн мал амьтад дансанд бүртгэлтэй Геррефорд үүлдрийн 3.8 сая төгрөгийн 1 бухан бяруу, Шинэ хөдөө төслийн хүрээнд нийлүүлсэн 3.9 сая төгрөгийн 1 бухын бярууны нас дэвшилт хийгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтад “Үнэн зөв байх”, 5.1.5 дэх заалтад “Хэмжигдэхүйц байх”, 14.4.7 дахь заалтад Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартаар тогтоосон бусад зүйлс”, Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байсан тул нас дэвшилт хийж залруулга хийлгэлээ.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 2,787.0 сая төгрөг байснаас эцсийн үлдэгдэл 3,138.0 сая төгрөг болж 351.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/Сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Б	1	2	3=2-1
Барилга, байгууламж, орон сууц	2,721.8	3,069.3	347.5
Хуримтлагдсан элэгдэл	-454.5	-474.2	-19.8
Авто-тээврийн хэрэгсэл	490.0	413.1	-76.9

Хуримтлагдсан элэгдэл	-248.9	-224.5	24.4
Машин тоног төхөөрөмж(компьютер)	369.8	421.6	51.8
Хуримтлагдсан элэгдэл	-288.2	-321.1	-32.9
Тавилга, аж ахуйн эд хогшил	172.8	226.3	53.5
Хуримтлагдсан элэгдэл	-63.5	-68.7	-5.2
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	10.2	10.2	0.0
Программ хангамж	1.7	6.7	5.0
Хуримтлагдсан элэгдэл	-1.3	-1.7	-0.4
Бусад биет бус хөрөнгө	82.0	86.0	4.0
Хуримтлагдсан элэгдэл	-5.0	-5.0	0.0
Дүн	2,787.0	3,138.0	351.1

Эх сурвалж: Зүүнхангай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,138.0 сая төгрөг болж 351.1 сая төгрөгөөр өссөн нь барилга байгууламж 397.6 сая, машин тоног төхөөрөмж 57.3 сая, тавилга эд хогшил 61.5 сая, программ хангамж 5.0 сая, бусад биет бус хөрөнгө 4.0 сая, нийт 525.3 сая төгрөгөөр нэмэгдэж, 140.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө хасаж, 33.8 сая төгрөгийн элэгдэл тооцсонтой холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данстай холбоотой Төсвийн шууд захирагчдын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 200.0 сая төгрөгийн 1 алдаа илэрсэн. Үүнд:

Аудитын илрүүлэлт:

Зүүнхангай сумын Засаг даргын тамгын газар:

- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 69 дүгээр тогтоолын дагуу үнэ төлбөргүй шилжин ирсэн 200.0 сая төгрөгийн өртөгтэй “Увс 100” цогцолбор хөшөөг бүртгэлд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтад “Үнэн зөв байх”, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2 дахь заалтад “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байсан тул орлогод авч бүртгэлд тусгуулан залруулга хийлгэлээ.

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 1.8 сая төгрөг байснаас 80.4 сая болж 78.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/Сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Б	1	2	3=2-1
Ажилчидтай холбоотой өглөг	0.0	2.0	2.0
Байгууллагад төлөх өглөг	1.8	78.4	76.6
Дүн	1.8	80.4	78.6

Эх сурвалж: Зүүнхангай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны үлдэгдэл 80.4 сая төгрөг болж өссөн нь харьяа байгууллагын тогтмол зардлын өр 70.6 сая, Засаг даргын тамгын газрын мал тооллогын өр 4.5 сая, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын байгууллагад төлөх өглөг 3.3 сая, цалингийн өглөг 2.0 сая төгрөгийн өр төлбөр үүссэнээс шалтгаалжээ.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 3,461.6 сая төгрөг байснаас эцсийн үлдэгдэл 3,562.2 сая төгрөг болж 100.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 7 Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Б	1	2	3=2-1
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	436.5	436.5	-
Хуримтлагдсан үр дүн	2,894.5	3,042.6	148.1
Өмнөх үеийн үр дүн	2,370.9	2,942.0	571.1
Тайлант үеийн үр дүн	523.6	100.6	-423.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	130.6	83.0	-47.6
Дүн	3,461.6	3,562.1	100.5

Эх сурвалж: Зүүнхангай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 3,562.1 сая төгрөг болж, 100.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5.7 Орлогын данс

Тайлант онд татварын орлого 601.3 сая, татварын бус орлого 121.9 сая, тусламж санхүүжилтийн орлого 976.4 сая, нийт 1,699.6 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого орсон байна.

3.5.8 Зардлын данс

Зардлын данстай холбоотой Төсвийн шууд захирагчдын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 60.8 сая төгрөгийн 1 алдаа илэрсэн. Үүнд:

Аудитын илрүүлэлт:

Зүүнхангай сумын Ерөнхий боловсролын сургууль:

Зүүнхангай сумын сургууль нь 2023 оны төсвийн жилийн дундуур үнэ тарифын нэмэгдэлтэй холбоотойгоор үүссэн түлш, халаалтын өр төлбөрийг тайлант онд Шүүхийн шийдвэрийн дагуу 46.8 сая, 2025 оны түлш халаалтын өр төлбөрөөс 14.0 сая, нийт 60.8 сая төгрөгийг аймгийн Засаг даргын нэгдсэн данснаас төлснийг тайланд тусгаагүй орхигдуулсныг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтад "Үнэн зөв байх", Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байсан тул залруулга хийлгэлээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Зүүнхангай сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн Зүүнхангай сумын 2025 оны төсвийн тодотгол батлах тухай 5/01 дүгээр тогтоолд зааснаар Зүүнхангай сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд 592.1 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 616.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 104.1 хувиар биелүүлсэн байна.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Зүүнхангай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны төсвийн төсөлд санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 1,065.0 сая, урьд оны үлдэгдлээс санхүүжих 97.0 сая, ОНХС-ийн шилжүүлгээр 219.4 сая, ОНХС-ийн оны эхний үлдэгдлээс 27.6 сая, татварын болон татварын бус орлогоос 570.8 сая, Хоршоо хөгжүүлэх сангийн оны эхний үлдэгдлээс 42.7 сая, Хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөс 159.8 сая, өвс тэжээлийн эргэн төлөлтөөс 56.0 сая төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 11.0 сая, нийт 2,249.3 сая төгрөгийг санхүүжүүлэхээр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Зүүнхангай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны төсвийн зарлагыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 2/09 дүгээр тогтоолоор 2,279.2 сая төгрөгөөр баталж, 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 5/01 дүгээр тогтоолоор тодотгол хийж анх баталсан дүнгээс 152.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж 2,127.1 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд Засаг даргын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,518.1 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,810.5 сая төгрөгийг урсгал зардалд, 613.3 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 94.3 сая төгрөгийг эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 996.4 сая төгрөгийг аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, 269.4 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас, 507.0 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 61.8 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос, 46.9 сая төгрөгийг Хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөс, 636.7 сая төгрөгийг сумын татварын бус орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 996.4 сая төгрөгийг аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс, 257.3 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас, 793.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 140.2 сая төгрөгийг өөрийн орлогоос санхүүжүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,251.7 сая төгрөг буюу 89.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

Хүснэгт №8. Ерөнхий чиглэлийн судалгааны нэгтгэл

/Сая төгрөг/

№	Үзүүлэлт	Гүйцэтгэл		Нийт дүн
		Зүүнхангай ИТХ	Зүүнхангай ЗДТГ	
1	Программ хангамж	0.4	3.2	3.6
2	Унаа, хоолны зардал	1.3	13.5	14.8
3	Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний зардал	0.1	5.7	5.8
4	Гадаад томилолт, арга хэмжээ	0.0	0.0	0.0
5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал	0.0	0.0	0.0
6	Орон тоо	7.0	24.0	31.0
7	Хэвлэл мэдээлэл	0.0	0.0	0.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар 62.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 62.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 4.5 сая, дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан хөрөнгө 58.0 сая төгрөгийн санхүүжилтийг авч зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Зүүнхангай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Р.Аюуш гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Зүүнхангай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 19 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 13.2 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,038.6 сая төгрөгийн 1 хувь буюу 20.4 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 16.3 сая төгрөгөөр тогтоолоо. Материаллаг байдлыг шинж чанарын хувьд авч үзээгүй болно.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Зүүнхангай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 181 мэдээллээс хугацаандаа оруулсан 177, хугацаа хоцроож 1 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна. Мэдээлэх хугацаа болоогүй 3 мэдээлэл байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн аудитын байгууллагаас 2024-2025 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд дараах зөрчил илэрлээ. Үүнд :

Аудитын илрүүлэлт:

Зүүнхангай сумын Засаг даргын тамгын газар:

1. Зүүнхангай сумын Засаг даргын Тамгын газар нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байгаа нь Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж заасны дагуу байгууллагын үйл ажиллагааны онцлог, салбарын стандартууд болон хууль, эрх зүйн шаардлагуудад нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөж ажиллахгүй байгаа нь Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байсанд зөвлөмж өгсөн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Зүүнхангай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Зүүнхангай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар 116.2 сая төгрөгийн 1 зөрчилд албан шаардлагыг өгснийг хэрэгжүүлэн ажиллаж,

Биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 83 дугаар албан бичгээр Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлж санхүүгийн тайлангийн аудитын fas.audit.mn систем бүртгэсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/Сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	116.2	1	116.2	100%
Зөвлөмж					
Нийт дүн	1	116.2	1	116.2	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Зүүнхангай сумын Засаг даргын тамгын газрын бүтэц, орон тоог аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/16 дугаар захирамжийн хавсралтаар баталсан ч сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар тамгын газрын бүтэц, орон тоо, цалин нэмэгдлийг батлахдаа батлагдсан бүтэц, орон тоонд байхгүй сантехникч засварчин, 4 багийн төвийн сахиулыг гэрээтээр цалинжуулан ажиллаж байгааг дараагийн аудитаар анхаарч үзэх шаардлагатай гэж үзлээ.

4.7 Харьяа байгууллагуудын аудитын дүнгийн талаар

Зүүнхангай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн 2 төсвийн байгууллага, улсын төсвийн 4 байгууллагын тогтмол зардал, 2 тусгай сан, нийт 8 санхүүгийн тайланг нэгтгэгдсэн.

Аудитад хамрагдсан Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа орон нутгийн 1 байгууллагын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгч, 1 байгууллага, 2 санг түүвэрт хамруулсан.

Харьяа байгууллагуудад хийсэн аудитаар нийт 268.6 сая төгрөгийн 4 алдаа, зөрчил илэрснээс 268.6 сая төгрөгийн 3 алдааг залруулж, 1 зөрчилд зөвлөмж өглөө.

Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

Хүснэгт № 8 Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ЗДТГ	3	207.8	2	207.8					1	0
2	ИТХ										
3	Цэцэрлэг										
4	ЕБСургууль	1	60.8	1	60.8						
5	ЭМТ										
6	Соёлын төв										
7	ОНХС										
8	ХХС										
		4	268.6	3	268.6					1	0.0

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/Сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Зүүнхангай сум								
Дүн								
Нийт дүн								

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАН

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

P. Аюуш

/P. АЮУШ/

2026 оны 03 сарын 24-ний өдөр

